

УДИРДАХУЙН ЕРӨНХИЙ ОНОЛ

*Хууль сахиулахын их сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн
дэд профессор, доцент, доктор (Ph.D), Ц. Батбаяр*

RESEARCHIN WESTERN SOCIAL TRANFORMATION IS A CORE DISCIPLINE OF MODERN MANAGEMENT

Барууны нийгмийн өөрчлөлтийг судлах нь орчин үеийн менежментийн үндсэн чиглэл болох нь

Түлхүүр үг : *Аж үйлдвэржсэний дараах нийгмийн ажилчин, онолын мэдлэг, мэдээлэл, үйлчилгээний үйлдвэрлэл, бүтээлч хотууд, аж үйлдвэржсэний дараах нийгмийн олон хувилбарт шинж, эдийн засгийн бус нийгмийн институт, пост-эдийн засаг, мэдээлэлжсэн нийгэм.*

Abstract: D. Bell has designed the concept of post-industrial society, so that he gave his full attention to information, theoretical knowledge, service production, university, research center, engineers, scientists, technocrats, and meritocrats. Since analyzing service production problems, which had high capacity of micro intelligence. The concept of post-industrial society had been become research rout by western and Russian researchers.

Nowadays population number doesn't compile the main role into social development and huge structure had passed it's period, so microstructure has sprung off and cities have developed like creative cities, they're now had confirmed very effectively. And a new class' information worker' has sprung off and it has become a main force to determine the social relation, therefore they are the cores of contemporary development western social changes.

Удиртгал

Орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны онол, арга зүйг танин мэдэх чиглэлд суурь судалгаа хийсэн орнууд буюу улс орноо шинжлэх ухааны онолын үндэстэй төвлөж чадсан барууны нийгэм эдүгээ хөгжлийн креатив шатандаа шилжээд байна.

Орчин үеийн барууны мэдээлэлжсэн нийгмийн өөрчлөлтийн судалгаанд дорвитой хувь нэмэр оруулсан эрдэмтэдэд зүй ёсоор бид Д. Белл, О. Тоффлер, А. Турейн, Ж. Гелбрейт, Г. Кан, П. Дракер, Р. Флорид, Ю. Хаяши, В. Иноземцев, Д. В. Иванов, В. Гнедовский, И. И. Юзвишин нарын нэрийг дурдах ёстой. Эдгээр эрдэмтдийн зарим бүтээлд тулгуурлан уг өгүүллийг бичиж санаа төрсөн юм.

Нийгмийн томоохон өөрчлөлтүүд нь жирийн нэг эрэдм шинжилгээний өгүүллээр орж ирж, тухайн нийгмийг эрс өөрчилсөн түүх бий. Алдарт эдийн засагч А. Маршал “Ирээдүйн ажилчин анги” гэсэн далд утгатай асуулт тавьж, Д. Рисман АҮДН гэдэг нэр томъёог “Зав чөлөөтэй нийгэм” гэдэг утгаар анх хэрэглэж \1958\, 1959 оноос Д. Белл өөр утга агуулгаар баяжуулан шинжлэх ухааны эргэлтэд оруулж “Ирж буй аж үйлдвэржсэний дараахь нийгэм” 1973 \1976, 1999\ бүтээлдээ онолын хэмжээнд нарийвчлан хөгжүүлж, “би АҮДН гэж нэрлэе, дараагийн судлаачид өөр өөрсдийнхөөрөө нэрлэнэ биз” хэмээжээ. Үүнээс хойш уг үзэл баримтлал олон

судлаачдын судалгаа, шүүмжлэлийн объект болж, дараах гэсэн утга, үе шатыг илэрхийлсэн пост утвартай үзэл баримтлалууд үүсэх, өнөөгийн барууны нийгмийн өөрчлөлтийг тодорхойлох онолын ерөнхий загварын суурь болсон байна.

Үндсэн хэсэг

Барууны хөгжингүй нийгмүүдэд мэдээллийн ажилтан болох цагаан захтнуудын нийгмийн оюуны үйлдвэрлэлд оруулах хувь нэмэр өсч үйлчилгээний эдийн засгийн үндсэн бааз суурь нь мэргэжилтэй ажилчид болсноор шинэ аж үйлдвэрсэн нийгмийн ажилчин ангийн тухай төсөөлөлд зарчмын хувьд эргэлт гарсан.

Барууны нийгмийн өөрчлөлт улам болосвронгүй болохын хэрээр түүнийг томъёолсон томъёолууд ялгарч, судлаачид өөрсдийн судалгааны арга зүй, үзэл санаа, үнэт зүйлс, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн үүднээс тодорхойлж байгаа нь нийгэм эдийн засаг, соёл иргэншлийн цоо шинэ дүр зургийг бий болгож байгаа юм. Үүнд: АҮДН, Мэдээллийн, постмодерн, виртуаль, креатив аж үйлдвэрлэлийн, кибер, дижитал, сүлжээний, капитализмын дараах, эдийн засгийн дараахь, түүхийн дараах, гуравдагч давалгааны, дөрөвдөгч формацийн нийгэм хэмээн янз бүрээр тодорхойлох болсон байна.

Үечилсэн хөгжлийн онол ёсоор АҮӨ, АҮ, АҮДН-ийн онолууд бий болсноор уламжлалт газар тариалангийн нийгмийг аж үйлдвэр эрхлэгчдын нийгэм халж авснаас хойш нийгмийн шинжүүд үр хөврөлын шинжтэйгээр үүсч бүтэцжих хандлагатай холбоотойгоор олон янзаар тодорхойлогдох болсон нь нийгмийн организмын дүрс хэлбэр, төрөл зүйлүүд нь төсөөлөхийн аргагүй болж буйн илэрхийлэл болсон. Эдгээр онолуудад нийгмийн дэвшлийн шалгуурт техникийн ололт бус шинжлэх ухаан, технологийн ололт, мэдлэгт суурилсан боловсролын хөгжлийг заасан байдаг.

Нийгмийн тулгуур үйлдвэрлэл тэнхлэгээ сольж машины эрин үеэс оюуны технологид суурилсан шинэ хэлбэрт шилжих үйл явцыг ажиглан нийгмийн тулгуур үйлдвэрлэлийг тодорхойлж, нийгмийн үйлдвэрлэлийн материаллаг болон оюун санааны хэлбэрийн суурь ялгааг гаргаж ирсэн нь Д. Беллийн ололт болохоос нийгмийн байгууллаг бүхэлд нь задлан шинжлэх зорилт тавиагүй юм. Тэрээр АҮӨН¹, АҮН^{1 2}, АҮДН³-ийг зэрэгцүүлэн судлахын зэрэгцээ АҮН, АҮДН хоёрыг харьцуулан судлаж өөрийн онолын үзэл баримтлалыг болосвруулсан бөгөөд АҮДН-ийн үзэл баримтлалыг ойлгохын тулд түүний арга зүй, сэтгэлгээний арга барилог танин мэдэх шаардлагтай юм.

Д. Белл аж үйлдвэржихийн өмнөх, эхэн үеийн аж үйлдвэржилтийн, аж үйлдвэрсэн, өргөн хэрэглээний, эхэн үеийн аж үйлдвэрсэний дараах, мэдэгдэхүйц аж үйлдвэрсэний дараах гэж тав хуваагаад мэдэгдэхүйц гэдэгт АНУ, Япон, Канад, Франц, Швейцар, Герман, Бенилюкс зэргийг оруулж, оюуны өндөр багтаамжтай хүний бүхий л хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлүүд үүсэх тухай авч үзсэн байдаг⁴.

¹ D. Bell. The coming of Post industrial society. NY., 1999, P. foreword 1999, P. xxxv table 1, АҮӨН-Аж үйлдвэржихийн өмнөх нийгэм

\ Pre-industrial society \

² Мөн тэнд. foreword 1999, P. xxxv, table 1, АҮН-Аж үйлдвэрсэн нийгэм\ Industrial society \

³ Мөн тэнд foreword 1999, xxxv, table 1, АҮДН-Аж үйлдвэрсэний дараахь нийгэм\ Post-industrial society \, xxxv

⁴ D. Bell. The coming of Post industrial society. NY., 1999, P. 275

Мэдэгдэхүйц АУДН-ийн үндсэн шинжийг танин мэдсэнээр түүний бүрэн дүр төрхийг олж харах боломжтой юм. Үүнд: гол хандлага нь өнгөрсөнд бус ирээдүйд чиглэсэн байх ба нийгмийн үйлдвэрлэл нь мэдлэг, мэдээллийн үйлчилгээний үйлдвэрлэлд төвлөрч, онолын мэдлэгийн үүрэг, мэдээлэл боловсруулалт, мэргэжилтэй ажилчдын үүрэг ролийн өсөлт, хар ажилчдын бууралт болон үйлчилгээний салбарын ажилчид ДНБ, нийт ажил, үйлчилгээнд тэн хагасаас илүү хувийг эзлэж, цаашид тасралтгүй хөгжих болсон зэрэг бодит үйл явцууд нь АУДН-ийг АҮН-ээс ялгаж өгч байна. Гэхдээ хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэл нь огт алга болно гэсэн үг биш юм¹. Үйлчилгээний үйлдвэрлэл нь боловсролтой ажиллах хүчийг шаардах болсон нь нийгмийн өөрчлөлтийн гол хөдөлгүүр болж эхэлсэн.

Эдгээр бүх өөрчлөлтийн онолын үндэс, гол хүчин зүйл нь аж үйлдвэржилтийн суурин дээр бий болж түүний дараахь шатанд нийгмийн материаллаг хэрэгцээ үндсэндээ хангагдаж түүнээс өөр хосгүй шинжтэй хувь хүний оюун санааны хүрэн дэх олон талт, хэрэгцээ, сонирхол бий болсон нь уламжлалт эдийн засгийн системийг үндсээр нь өөрчлөж, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээ тасралтгүй өсч энэ нь пост-эдийн засгийн суурийн үндэс болсон байна.

Эрин үе болгонд толгойлогч парадигмууд нь солигдож тухайн шинжлэх ухааны арга зүй, онолын суурь тухайн нийгмийн өөрчлөлтийг чиглүүлэгч болж ирснийг шинжлэх ухааны түүхээс харж болох юм. Шинжлэх ухааны арга зүйн ертөнц ч үечилсэн хөгжлийн үзэл баримтлал ёсоор өөрчлөгдөж өнөөдөр абстракт сэтгэлгээ, загварчлал, онолын мэдлэгийн кодчилол, оюуны технологи, системийн онол, тоглоомын онол голлох болж, эрх мэдлийн үндэс нь улс төрийн байдал бус ур чадвар, нийгмийн байгууллагын төвлөрөл нь пүүс, фирм бус эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, их сургууль инновацийн нэгдэл, давамгайлагч хэлбэр нь бизнесмен бус эрдэмтэн судлаачид, инженерүүд, ангийн суурь нь улс төрийн байгууллага өмч хөрөнгө бус, техникийн ур чадвар бүхий технократууд, гол харилцаа нь теле-харилцаа, компьютерын виртуаль орчинд өрнөж, бүтээгдэхүүн үйлчилгээ нь өндөр хурдны зам \шинэ дэд бүтэц\ болох сүлжээгээр тээвэрлэгдэж, баялаг нь хөдөлмөр. капитал бус мэдлэг, мэдээлэл, техно-эдийн засгийн үндэс нь шинжлэх ухааны боловсруулалтууд, шинжлэх ухаанд суурилсан бүтээлч аж үйлдвэрлэл² болсноор анхан шатны нөөц нь хүний капитал, хязгаарлах хүчин зүйл нь онолын мэдлэг, стратеги нь ур чадвар, дахин сургалт, нэмэлт боловсрол, гол хүн нь эрдэмтэн, инженер, технократ, меритократууд, гол бүтэц нь онолын мэдлэгт суурилсан бичил оюуны фабрикиуд, гол институц нь их сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүд болж инновацийн нөлөө ихсэж венчур буюу олон төслүүдийг зэрэг хэрэгжүүлж нэг нь нөгөөгийнхөө эрсдлийг даадаг инновацлагдсан үйлдвэрлэлд төвлөрсөн хотууд хэлбэрээр хөгжих болсон. Энд хувь хүний онолын мэдлэг, мэдээлэл, ур чадвар, бүтээгч чанар, цаг, хөдөлмөр, үнэт зүйлс зэрэг давуу талуудад суурилсан оюуны өндөр багтаамжтай пост эдийн засгийн хувьд өндөр зардлыг шаардсан үйлдвэрлэл зонхилж дэлхийн хотууд креатив шинжийг олохын төлөө өрсөлдөх болсон байна. Хөгжлийн чиг хандлага нь улс үндэстний

хэмжээний том корпорацууд гэхээсээ илүү жижиг хот маягаар өөрчлөгдөж, эдийн засгийн зүрх нь гар утасны компанууд болсон байна.

Үйлчилгээний эдийн засгийн үндсэн нөөц нь мэдлэг, мэдээлэл дээр бүтээгдсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нь бодит зардлыг хэмнэхэд зориулагдсан, мэдээлэл боловсруулалт, сүлжээ, программчлал, онолын мэдлэгийн кодчлолд үндэслэгдсэн мэдээллийг эмхлэх, хадгалах, хуваарилах, тээвэрлэх, арилжаалах, хэрэглээ болгох, мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үндэслэгдсэн АҮДН-ийн эдийн засгийн гуравдагч, дөрөвдөгч, тавдагч секторууд хөгжиж байна.

Т. Умесао “ мэдээллийн нийгэм ” гэдэг ойлголтыг гаргаж ирсэн нь үйлчилгээ, мэдээлэл, үйлдвэрлэлд анхаарлыг илүүтэй хандуулах болсон юм. Ийнхүү шинэ хөдөлмөрийн хуваарь бий болгож мэргэжилтнүүд, өндөр бүтээмжтэй хүмүүс ажлын цагаас гадуур мэргэжлийн үйл ажиллагаагаа илүү идэвхижүүлж, үйлдвэрлэлийн процесст илүү их татагдан бусад хүмүүсийн бүтээсэн мэдээлэл, мэдлэг ихээр хэрэглэгдэх болж уламжлалт үйлдвэрлэлд байдаггүй материаллаг бус урамшууллын нөлөөнд улам бүр орох болсноор чөлөөт цаг, ажлын байр, үйлдвэрлэл, хэрэглээ хоёрын зааг устгахад хүрч байна.

Ялангуяа их сургуулийн профессоруудад хичээл заах нь гол асуудал биш болж, онолын мэдлэг мэдээллийг цуглуулах анализ хийх шинэ үүрэг буй болсон байна. Постиндустриаль орнуудын эрдэмтэд өөрийгөө хөгжүүлэх нь гол үнэт зүйл болж, тэд судалгааныхаа завсраар хичээл заадаг бол постсоциалист орны эрдэмтэд хичээлийнхээ хажуугаар судалгаа хийж байгаа үнэт зүйл, соёлын томоохон ялгааг харуулж байгаа юм.

Нөгөө талаас Беллийн ярьдаг онолын мэдлэгийн гүйцэтгэх үүрэг нь өсөөд зогсохгүй олон шинжлэх ухааны мэдлэгийн интеграц нь аж үйлдвэржсэний дараах ертөнцийг улам олон хувилбарт шинж бүхий систем болгон өөрчилж байна. АҮДН-ийн үзэл баримтлалыг амьдралын аль нэг тал дээр хөгжүүлж байгаа нь АҮДН-ийн олон хувилбарт шинжийн асуудлыг үүсгэж, мэдээлэлжсэн нийгэм, үйлчилгээний үйлдвэрлэл, прозьюмер, компьюникац, креатив аж үйлдвэрлэл, пост-эдийн засаг, виртуаль нийгэм, сүлжээний капитализм, тел-харилцааны нийгэм, мэдлэгийн эдийн засаг, үүрэн холбооны нийгэм, тархинд суурилсан нийгэм зэрэг улам бүр нарийсч буй нийгмийн өөрчлөлтийг илэрхийлэх болсон.

Хувь хүний амьдралд мэдээллийн гүйцэтгэж буй үүрэг, оруулж буй хувь нэмрийг тооцоолох, тоймлох боломжгүй болж, мэдээллийн хамрах хүрээ богино хугацаанд асар өргөжиж байгаа нь мэдээлэлд суурилсан нийгмийн үндэс болсон. АҮН-ийн бөөндөх үйлдвэрлэлийг мэдээллийн нийгэм хувьчлан авснаар иргэний нийгмийн тархаан сондгойруулах хэлбэрт оруулж байна¹. Ингэснээр өмч хөрөнгө, зах зээл, нийгэмшил, хувь хүний эрх чөлөөний мөн чанар, түүний бүтээгч чадвар, үнэт зүйлс, цаг хугацаа, хөдөлмөрийг ойлгох ойлголт, ертөнцийг үзэх үзэлд зарчмын өөрчлөлт гарсан. Мэдээллийн хурдац дунд ирээдүй өөрөө бүтээгдэж буй өнөө үед гурав дахь мянганыг нийгмийн шинжлэх ухааны шинэ арга зүйгээр судлахын тулд тухайн эрин үе дэх сэтгэх арга, нийгмийн нөхцөл байдал, технологийн дэвшил, хөдөлмөр, уран бүтээл болж хувирахад нөлөөлж байгаа бодит хийгээд хийсвэр хүчин зүйлс, түүнээс гарч болох болзошгүй үр дагварууд, шинээр бий болж буй харилцааны шинж чанар, үнэт

3. Д. Төмөртогоо, Д Ганбат Ардчилсан засагал нээлтгүй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2006, 73-75 дахь тал

зүйлс, үйлдвэрлэлийн хэлбэр, эдийн засгийн бүтцэд гарч буй өөрчлөлтийн онцлогийг танин мэдэх шаардлагтай юм.

Үйлдвэрлэл, хэрэглээ, чөлөөт цаг, ажлын байр гэсэн цикл бий болж нормчлогдсон ажлын өдрөөс гадуурх хөдөлмөрийн хуваарь бий болсноор 70 оны дунд үеэс үүссэн ер бусын үзэгдлийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ба баялаг, үйлчилгээний идэвхитэй хэрэглээг өөртөө шингээсэн прозьюмер тогтож байна гэж барууны авторууд үзэж байна. Энэ нь цэвэр хэрэглээ, цэвэр үйлдвэрлэл бус харин үйлчилгээ, үйл ажиллагааны хийсвэр хэлбэр юм.

Өндөр технологи, үнэтэй техникийг эзэмшиж байгаа корпорациуд ажилчдын бие даасан, бүрэн эрх чөлөөт байдлыг хязгаарлаж байгаа ч тэд компанитай хамтарч ажиллаж байгаа болохоос компаны ажилчин шиг ажиллахгүй болсон ба хүнээс салгаж үл болох мэдлэг голлох болсноор өмчөөс хамааралтай аж үйлдвэржсэн соёл иргэншлээс эрс өөр шатанд шилжсэн нь Т. Фукуямагийн тезис үнэн болохыг баталсан.

Шинэ корпораци, их сургууль, эмнэлэгүүд нь өөрийнхөө зорилгыг ажилчдынхаа хүсэл эрмэлзлэл, нийгмийн сонирхолтой зохицуулахаас өөр аргагүй болж байгаа нь эдийн засгийн бус нийгмийн институт болон хувирахад хүргэж байгаа нь содон үзэгдэл бөгөөд орчин үеийн менежмент уг контекстийг ойлгохгүйгээр ганц ч олигтой алхам хийх боломжгүй боллоо. Ялангуяа их сургууль, эмнэлэг гэх мэт төрийн үйлчилгээний гол цөм болж, үйлчилгээний эдийн засгийн гол агент болов. Удирдлага болон ажилчдын мэргэжлийн түвшин зэрэгцэн ирж удирдлага нь бэлэг тэмдгийн шинжтэй болж, эрх зүйн баримт болж үлдэх хандлага ажиглагдаж, мэдлэгийн нийгэм дахь мэргэжилтнүүд, профессоруудын үнэ цэнэ өсч, тэднийг хадгалж үлдэх нь гол асуулт болсон.

Оюун санааны хүрээнд гарч буй эрх чөлөөний өөрчлөлттэй холбоотойгоор хөдөлмөр, үйлдвэрлэлийн хэрэгсэл нэгдэх чиглэлд орж хөдөлмөрийн шинж чанар өөрчлөгдсөн нь эдийн засгийн системийн суурь шинжийг өөрчлөж, онолын мэдлэг дээр суурилсан өмчийн хэлбэр үүсч хүнийг бүх асуудлын зангилаа цэг болгож төвд нь тавьж, ашгийн бус харилцаа, идэвхитэй зохицуулалт, прозьюмер, чөлөөт цаг, ажлын байр, үйлдвэрлэл хэрэглээний зааг арилсан зэрэг шинэ бодит байдал бий болсон нь өмчөөс хамааралтай аж үйлдвэржсэн соёл иргэншлээс эрс ялгаатай онолын янз бүрийн төрлийн мэдлэгийн интеграцид суурилсан шинжлэх ухаан, технологи, инновацийн бичил бүтэц, кластерүүд аж үйлдвэржсэний дараах нийгэм-эдийн засгийн гол агент болж байна.

Интернет нь дэлхий нийтийн виртуаль орон зайг бий болгосноор мэдээллийн нийгмийн парадигмыг бодит зүйл болгох урьдчилсан нөхцөл бүрэлдэж, нийгмийн бүхий л хүрээний мэдээллийн бүтээн байгуулалт, хувиарлалт, сарнилт, интеграц, манипуляц нь мэдээллийн нийгмийн анхдагч суурь болсон бол хоёрдогч суурьд тархин дахь процесс техникийн системүүдийн зэрэгцээ боломжууд олдсон. Гурав дахь суурь нь нэг талаас тооцоолон бодох техникийн бааз суурь нөгөө талаас эрх чөлөө, ардчиллын нийгэм улс төрийн ололт нь боломжтой зүйл болсон зэрэг объектив хийгээд субъектив хүчин зүйлсийн нэгдэлт үйл явцыг багтааж байна.

Мэдээллийн нийгмийн мөн чанар нь мэдээлэл, мэдлэг нь хөгжлийн нөөц, хөдөлгөгч хүч, өрсөлдөх чадварыг тодорхойлогч нөхцөл болж мэдээллийн үйлдвэрлэл өсч, зах зээл бүрэлдэн тогтсон, боловсрол, хөдөлмөр, нийгмийн амьдрал, амралтын загварууд үндсээрээ өөрчлөгдсөн, үнэт зүйл нь бараа таваарын хэрэглээ бус цаг

хугацаа болсон зэрэг харилцан хамаарал бүхий үйл явцуудыг ойлгох хэрэгтэй. Аж үйлдвэржсэн нийгэмд ажилчид үйлдвэрлэгчид болж байсан бол мэдээллийн нийгэмд тэд өмч хөрөнгө болсноор хөдөлмөр эрхлэлтийн шинэ шинж чанар, хэлбэрт шилжиж, бүтэц үүргийн ялгарал бий болж, тэдний үүрэг нийгмийн гэрээний чухал хэсэг болж хувирсан.

Мэдээллийн нийгмийн бүрэлдэн тогтсон шалтгаанд Оросын судлаачид эдийн засгийн хөгжлийн урт удаан хугацааны чиг хандлага, технологийн дэвшил, нөгөө талаас тухайн улс орны нийгэм, соёл, эдийн засгийн дэд бүтэц зэргийг оруулж байна. А.И. Ракитов мэдээллийн нийгмийн үндсэн шалгуур нь байгаа мэдээллийн тоо, чанар, үр ашигтай дамжуулах, боловсруулах явдлаар хэмжигдэнэ. Шаардлага нь мэдээллийг хүртээмжтэй, амьдрал үйлдвэрлэлд чиглэгдсэн байх явдал гэж үзэж байна. Үндсэн шинжид мэдээллийн нэгдсэн орон зайд мэдээллийн интеграци, солилцооны процесс гүнзгийрсэн, мэдээлэл нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодит үндэс болсон зэргийг хамааруулж байгаа бол олон улсын мэдээлэлжүүлэлтийн академийн ерөнхийлөгч оросын эрдэмтэн И. И. Юзвишин “ Информациология ” бүтээлдээ мэдээллийн технологи нь нийгмийн хөгжлийг автоматаар 25-30 % хүртэл өсгөдөг болохын өөрийн судалгаандаа үндэслэн нотолсон¹.

Дүгнэлт

Д. Белл АҮДН-ийг мэдээллийн нийгэм мөн хэмээн үзэж энэ хоёр ойлголтыг бараг адилтгасан байдаг бол харин мэдээллийн нийгмийн онолыг үндэслэгчид энэ онолоо АҮДН-ийн онолтой зэрэгцэж бүтээсэн байдаг.

Мэдээллийн нийгмийн нэг чухал үүрэг нь нийгмийн ашиг сонирхол зөв илэрхийлэгдсэн, төрийн бодлогоор шийдвэрлэгдэх явдал бол, гол зарчим нь тогтвортой хөгжил, байгаль, нийгмийн харилцаа, соёлын өвийг хамгаалах, ардчилал, ажлын байр, үйлдвэрлэл, зөв шударга өрсөлдөөн, тэгш эрх, олон улсын хамтын харилцаа, хөгжиж буй орнуудтай харьцах харилцааг дээшлүүлэх зэрэг юм.

Орчин үеийн глобалчлагдсан мэдээллийн дотоод бүтцийн нэг чухал хэсэг нь ардчиллын үнэт зүйлийг өөрөөр нь хөгжүүлэх, тэнцвэрийг барих, интеграцийг бүрдүүлэх зэрэг оюуны чадварыг хөгжүүлэх, нөгөө талаас хүн, техникээс бус харин техник хүний хэрэгцээнд дасан зохицох явдал ба техник технологи, мэдээлэл хоёр нь ямар үүрэг гүйцэтгэж байгаа нь мэдээллийн нийгмийн болон орчин үеийн менежментийн гол хэлэлцэх асуудал болсон байна.

Мэдээлэлжсэн хотуудын микро газар зүй, лидер хотуудын макро амжилтын газар зүйн хэлбэр хөгжих загвар бий болсон нь Америк, Европын холбоо, Швед, Хятадын зарим хотуудад ажиглагдсан ба европын холбооны зарим хотууд креатив аж үйлдвэрлэлээр АНУ-аас давах болсон нь тэдний улс төрийн бодлого, шинжлэх ухаан, соёлын үйлдвэрлэлийг хэрхэн дэмжиж байгаатай нь шууд холбоотой болох нь харагдаж байна.

Аж үйлдвэржсэн нийгэм нь бүтээгдэхүүн гэдэг утгаас гарч ирсэн бол аж үйлдвэржсэний дараахь нийгэм буюу мэдээллийн нийгэм нь бүтээгдэхүүний сүүлийн шатыг өөрчилсөн соёл юм гэж А.Турейн үзсэн нь оюуны соёлын үйлдвэрлэлийн хүрээ нь нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн гол тэнхлэг болсонд уг үзэгдэл, үзэл баримтлалын амин сүнс оршиж байгаа юм. Виртуаль хэлбэрээр бүтээгдсэн жинхэнэ бус бодит

1. И.И. Юзвишин. Информациология. М., 1996, С. 65-68

байдал нь орчин үеийн хэрэглэгчдийн таашаалд нийцэж байгаад өнөөгийн нийгмийн өөрчлөлтийн онцлог оршиж, энэ нь виртуаль орчин болон оюун санааны феномен дэх өөрийгөө байнга шинэчлэн өөрчлөн, хувиргаж байдаг тодорхой хэсгийн дахин үйлдвэрлэлттэй холбоотой нь харагдаж байна.

Нийгмийн организмын цусан хангамж болсон өндөр хурдны \зам\ сүлжээнд суурилсан компьютертэй болон компьютергүй, тээвэрлэлтгүй шинэ хэлбэрүүд бий болсноор эдийн засгийн эрин үед капитал, хөдөлмөр гол байсан уламжлалт ойлгоцыг шахан гаргаж мэдлэг, мэдээллийн хомсдол нь организм орших, мөхөх, амьд үлдэх, гол үндэс, хязгаарлах хүчин зүйл болсоор байна.

Мэдлэг, мэдээллийг эдийн засагжуулах чадавхи нь нийгмийн организмын оршин тогтнох хийгээд, өрсөлдөх чадварын гол үзүүлэлт болж үүнтэй холбоотойгоор өндөр хурд, амьд мэдрэмж, үр ашигтайгаар мэдээллийг солилцох нь нийгмийн организм эд эсээрээ шинэчлэгдэх, шинэ залуу эд эсүүд урган төлжих, улам залуужин хүчирхэгжихэд түүний хөдөлгөгч хүч болсон мэдээллийн ажилчдын хүч, хөдөлмөр, үйл ажиллагаа гол үүргийг гүйцэтгэх болсон.

Ийм төрлийн болон шинжлэх ухааны бусад суурь судлагаанд хэр зэрэг хөрөнгө оруулалт хийхээс тухайн улс үндэстний хувь заяа хөгжлийн чиг хандлага, цаашдын нийгмийн өөрчлөлтийн хурд далайц, чанар ихээхэн хамаардаг нь батлагдсан бөгөөд өнөрсөн 20 жилд бид зах зээлийн эдийн засаг, ардчиллын үнэт зүйлсийг соёл гэдэг утгаар ойлгож, онолын мэдлэгийн түвшинд танин мэдэж чадаагүйгээс бий болсон олон алдаа, завхрал, гарз хохирлыг дахин давтахгүйн тулд зарим хэсгээрээ нэгэнт шилжин орчихсон, бидний зайлшгүй шилжин орох мэдээллийн нийгмийн талаарх суурь судлагааг бодлогын хэмжээнд авч үзэн төрөөс дэмжиж хөрөнгө оруулалт хийх нь нийгмийн бүх хүрээнд гарч болох эерэг\сөрөг\ өөрчлөлтүүдийн онолын суурь байх болно. Учир нь 1914 оноос эхлэлтэй шинэ буюу new хэмээх угтвартай онолууд нь нэлээд цаг хугацааг авч хөгжиж ирсэн бол 1958 оноос дараах буюу пост угтвартай орчин үеийн нийгмийн өөрчлөлтийн онолууд үүсч улмаар маш богино хугацаанд өрнөж, онолын мэдлэг, мэдээлэл, үйлчилгээний үйлдвэрлэлийн төрлүүдэд ялгарч тухайн нийгмийн организмын орших, эс оршихуйн үндэс болсныг мэдрэхгүй өнгөрч үл болно. Цаг хугацаа хүн төрөлхтний нийгмийн гол үнэт зүйл болсонд өнөөгийн нийгмийн өөрчлөлтийн хурд, далайц, шинж чанар, хэмнэл, хэв маяг, өнгө төрх оршиж байгаа юм. Эрдэмтэн, инженер, судлаач, мэргэжилтнүүдийн тоо, чанар, тэдний хөдөлмөр, судалгааны чиглэл нь тухайн улс үндэстний баялаг болсноор баялаг хэмээх ойлголт үндсээрээ өөрчлөгдөж түүнийг ойлгох, үнэлэх, бүтэц, удирдлага нэхэмжлэгдэх болсонд уг нийгмийн өөрчлөлтийн зарчмын эргэлт орших болов уу.

Иймд бид мэдээллийн болон мэдлэгийн менежментийн философиийг хөгжүүлэх профессорын баг юмуу эсвэл магиструудын судалгааны баг байгуулах шаардлагатай байна. Нийгмийг эхлээд судалж, танин мэдэж, ойлгож байж, дараа нь нийгмийн өөрчлөлтийг удирдах арга ухааны олох нь шинжлэх ухааны логикийн хувьд таарч байгаа юм.